

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 62, 64, 65, 67 дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 16.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доорхи асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.


4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга  
Гишүүд

Н.Бүрэнжаргал  
Г.Алтантуяа  
Б.Болормаа

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг ТУЗ-ийн нарийн бичиг /Б.Ундрах/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
*Б. Наранзуул* Б.НАРАНЗУЛ